

БАНКНЫ ТАЙЛАН БОЛОН МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ ИРҮҮЛЭХ ЖУРАМ

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Банкны тайлан болон мэдээ, мэдээлэл ирүүлэх журмын зорилго нь хадгаламжийн албан журмын даатгалын үйл ажиллагаанд оролцож буй Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд заасан албан журмын даатгал төлөх үүрэг бүхий банк (цаашид “Банк” гэх) Хадгаламжийн даатгалын корпораци (цаашид “Корпораци” гэх)-ийг хуулиар олгогдсон чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай тайлан болон мэдээ, мэдээллээр хангахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Корпораци нь Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.1 болон 21.1.2 дахь заалтуудад заасны дагуу банкны тайлан болон мэдээ, мэдээллийг банкнаас авах эрхтэй.
- 1.3 Энэхүү журамд заасан нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
 - 1.3.1 “цахим маягт” гэж энэхүү журмын хавсралт загваруудыг;
 - 1.3.2 “SCV” /Single customer view/ гэж “Нэг харилцагчийн зарчим” гэх загварыг;
 - 1.3.3 “цахимаар” гэж API /Application programming interface/ сүлжээгээр дамжуулан илгээхийг;
 - 1.3.4 “encryption” гэж өгөгдлийг нууцлах эсвэл зөвшөөрөлгүй хэрэглэгчдэд нэвтрэх боломжгүй болгохын тулд кодчилдог процесс гэж тус тус ойлгоно.

ХОЁР.БАНКНЫ ҮҮРЭГ

- 2.1 Банк нь Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт заасны дагуу тайлан болон мэдээ, мэдээллийг энэхүү журмын хавсралтаар батлагдсан загвар маягтын дагуу бэлтгэн цахимаар сар бүр энэхүү журамд заасан хугацаанд Корпорацид ирүүлнэ.
- 2.2 Банк нь Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэгт заасны дагуу нэмэлт тайлан болон мэдээ, мэдээллийг Корпорацийн хүсэлтийн дагуу заасан хугацаанд, тогтоосон загварын дагуу бэлтгэн ирүүлнэ.
- 2.3 Корпораци тайлан болон мэдээ, мэдээлэл ирүүлэх цахим маягыг шаардлагатай тохиолдолд өөрчилж болох ба Банк тухайн өөрчлөлтийн дагуу тайлан болон мэдээ, мэдээллийг бэлтгэн ирүүлнэ.
- 2.4 Корпораци нэмэлт тайлан болон мэдээ, мэдээлэл хүсэхдээ тодорхой хугацаа заагаагүй бол Банк хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдөрт багтаан гаргаж өгнө.
- 2.5 Цахим маягтын дагуу хүргүүлэх тайлан болон мэдээ, мэдээллийг тухайн асуудал хариуцсан нэгжийн удирдлага болон түүнтэй адилтгах албан тушаалтан гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулан ирүүлнэ.
- 2.6 Банк нь “Хадгаламж эзэмшигчдийн мэдээллийг хүлээн авах SCV загвар” (хавсралт 6)-ын дагуу мэдээлэл ирүүлэх бөгөөд “*”-оор тэмдэглэснээс бусад талбаруудыг нууцлалгүй ирүүлнэ.
- 2.7 Банк нь шаардлагатай тохиолдолд “Хадгаламж эзэмшигчдийн мэдээллийг хүлээн авах SCV загвар” (хавсралт 6)-ын дагуу мэдээлэл ирүүлэхдээ бүх талбаруудыг корпорацийн заасан хугацаанд нууцлалгүй ирүүлнэ.
- 2.8 Банк нь Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5 дахь хэсэгт заасны дагуу хадгаламжийн даатгалын тогтолцоо, даатгалын нөхөн төлбөрийн хэмжээний талаарх мэдээллийг хадгаламж эзэмшигчдэд тогтмол хүргэсэн

тухай тайлан, мэдээг цахим маягт (хавсралт 7)-ын дагуу contacts@dicom.mn цахим шууданд жил тутам бэлтгэн ирүүлнэ.

ГУРАВ.КОРПОРАЦИЙН ҮҮРЭГ

- 3.1 Корпораци бүрэн эрхийнхээ хүрээнд Банкнаас авсан тайлан болон мэдээ, мэдээллийг Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2, 20 дугаар зүйлийн 20.1 болон 21 дүгээр зүйлийн 21.1.7 дахь хэсэгт заасан үйл ажиллагааны хүрээнд ашиглана.
- 3.2 Корпораци Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт заасны дагуу хүлээн авсан Банкны тайлан болон мэдээ, мэдээллийн нууцыг чандлан хадгална.
- 3.3 Корпораци Банкнаас ирүүлсэн тайлан болон мэдээ, мэдээллийн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- 3.4 Банкнаас ирүүлж буй тайлан болон мэдээ, мэдээллийг хүлээн авах болон ашиглах албан тушаалтан нь мэдээллийн нууцлалыг чандлан сахих үүргийг Корпорацийн нууц хадгалах гэрээгээр хүлээсэн байна.
- 3.5 Корпораци эрх бүхий байгууллага хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхээс бусад тохиолдолд гуравдагч этгээдэд тайлан болон мэдээ, мэдээллийг задруулахгүй байна.

ДӨРӨВ.ТАЙЛАН ИРҮҮЛЭХ ХЭЛБЭР БОЛОН ХУГАЦАА

- 4.1 Банк Корпорацид хүргүүлэх тайлан болон мэдээ мэдээллийг өмнөх сарын сүүлийн өдрийн байдлаар цахим маягтын дагуу бэлтгэн дараа сарын 10-ны өдрийн дотор цахимаар ирүүлнэ. Зөвхөн “Хадгаламж эзэмшигчдийн мэдээллийг хүлээн авах SCV загвар” (хавсралт 6)-ын дагуу тайлан болон мэдээ, мэдээллийг өмнөх улирлын сүүлийн өдрийн байдлаар цахим маягтын дагуу бэлтгэн дараа улирлын 10-ны өдрийн дотор цахимаар ирүүлнэ.
- 4.2 Банк тайлан болон мэдээ, мэдээллийг алдаатай хүргүүлсэн тохиолдолд энэ тухай Корпорацид яаралтай мэдэгдэх ба мэдэгдсэнээс хойш ажлын 3 өдөрт багтаан залруулсан тайлан болон мэдээ, мэдээллийг ирүүлнэ.
- 4.3 Корпораци шаардлагатай тохиолдолд Банкны ирүүлсэн тайлан болон мэдээ, мэдээллийг баталгаажуулахдаа Монголбанкны тайлан, мэдээтэй тулган баталгаажуулна.
- 4.4 Хэрэв Банкнаас ирүүлсэн тайлан болон мэдээ, мэдээлэл нь Монголбанкнаас ирүүлсэн тайлантай зөрүүтэй болохыг Корпораци илрүүлбэл банканд мэдэгдэх ба энэ тохиолдолд Банк залруулсан тайлан болон мэдээ, мэдээллийг ажлын 3 өдөрт багтаан Корпорацид ирүүлнэ.
- 4.5 Банк тайлан болон мэдээ мэдээллийг, зөвхөн Корпорациас ирүүлсэн цахим маягтын дагуу үнэн, зөв бэлтгэн ирүүлнэ.
- 4.6 Корпораци цахим маягтын дагуу ирүүлэх тайлан болон мэдээ, мэдээллийг шаардлагатай тохиолдолд цаасан хэлбэрээр авч болно.
- 4.7 Корпораци энэхүү журмын 4.1-т заасан цахим маягтын дагуу ирүүлсэн тайлан болон мэдээ, мэдээллийг мэдээллийн сан үүсгэн хадгалах бөгөөд тайлан ирсэн хамгийн сүүлийн огноогоор хүлээн авсанд тооцно.
- 4.8 Корпораци энэхүү журмын 4.1 болон 4.2-т заасан хугацаанаас хойш ирүүлсэн банкны тайлан болон мэдээ, мэдээллийг хугацаа хоцорсонд тооцно.
- 4.9 Банк “Хадгаламж эзэмшигчдийн мэдээллийг хүлээн авах SCV загвар” (хавсралт-6)-ын дагуу, мэдээлэл ирүүлэхдээ “*”-оор тэмдэглэсэн талбаруудыг нууцалж болно.
- 4.10 Банк энэхүү журмын 4.9-д заасан хөрвүүлэлтийг хийхдээ тухайн талбар бүрт дахин давтагдахгүй цор ганц утга оноож, тогтмол ашиглана.

ТАВ.ХАРИУЦЛАГА

- 5.1 Банк нь Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэгт заасны дагуу Корпорацид хүргүүлсэн тайлан болон мэдээ, мэдээллийн үнэн зөв, иж бүрэн байдлыг хариуцна.
- 5.2 Корпорацийн улсын байцаагч хуулиар олгогдсон эрхийнхээ хүрээнд Банканд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх үедээ Банкнаас Корпорацид ирүүлсэн тайлан болон мэдээ, мэдээлэл нь алдаатай байгааг илрүүлсэн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
- 5.3 Банк энэхүү журмын дагуу үүргээ биелүүлээгүйн улмаас Корпорацид учирсан аливаа хохирол, зайлшгүй олох байсан орлогыг хариуцах бөгөөд хэрэв татгалзвал шүүхийн журмаар шийдвэрлүүлнэ.

ЗУРГАА.БУСАД

- 6.1 Энэхүү журмыг 2024 оны ... дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.
- 6.2 Энэхүү журмын дагуу тайлан болон мэдээ, мэдээллийг үнэн зөв, хугацаандаа ирүүлэх нь банкны эрсдэлийн түвшинг тодорхойлох нэг үзүүлэлт болно.

ДААТГАЛЫН ХУРААМЖ ТООЦОХ ТАЙЛАН

Банкны нэр:

Огноо: (yyyy.mm.dd)

Банкны код:

/нэгж.төг/

№	Үзүүлэлт	Томьёолол	Тайлант сарын үлдэгдэл	Дансны тоо	Эзэмшигчдийн тоо
A	Нийт харилцах, хадгаламж	(1+4)			
1	Иргэд	(2+3)			
2	Харилцах				
3	Хадгаламж				
4	Хуулийн этгээд	(5+6+7)			
5	Харилцах				
6	Хадгаламж				
7	Банк, СБ-аас татсан харилцах, хадгаламж				
B	Албан журмын даатгалд хамаарахгүй нийт харилцах, хадгаламж (хуулийн 7.1)	(8+...+11)			
8	Нэргүй, дугаарласан, эсвэл хуурамч нэрээр нээсэн данс (хуулийн 7.1.1)				
9	Нэргүй хадгаламжийн сертификат болон бусад төрлийн нэргүй санхүүгийн хэрэгсэл (хуулийн 7.1.2)				
10	Нэрлэсэн үнээр эргэж төлөгдөхгүй харилцах, хадгаламж (хуулийн 7.1.3)				
11	Монголбанкнаас байршуулсан эх үүсвэр				
B	Албан журмын даатгалд хамаарахгүй буюу албан журмын даатгалын нөхөн төлбөр төлөхгүй этгээд (хуулийн 7.2)	(12+...+17)			
12	Банк (хуулийн 7.2.1)				
13	Төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага (хуулийн 7.2.2)				
14	Эрүүл мэндийн, тэтгэврийн болон нийгмийн албан журмын даатгалын сан (хуулийн 7.2.3)				
15	Банкны тухай хуулийн 3.1.2-т заасан банкны холбогдох этгээд (хуулийн 7.2.4)				
16	Сүүлийн гурван жилийн хугацаанд банкны санхүүгийн тайланд аудит хийсэн аудитор болон аудитын байгууллага (хуулийн 7.2.5)				
17	БУСАД ЭТГЭЭДҮҮД: - Монголбанкны хяналт шалгалтын тайлангаар банкны санхүүгийн байдал муудахад нөлөөлсөн, банкны үйлчилгээ авахдаа санхүүгийн давуу эрх эдэлсэн нь				

	<p>тогтоогдсон дор дурдсан хадгаламж эзэмшигч: (хуулийн 7.2.6)</p> <ul style="list-style-type: none"> - Гүйлгээний төрөл, эрсдэлийн түвшин, зээлдэгчийн төлбөрийн чадвар болон барьцааны төрөл зэргийг харгалзан үзэхэд бусад хадгаламж эзэмшигчээс онцгой нөхцөлтэй зээл авсан; (хуулийн 7.2.6а) - Банкны бусад хадгаламж эзэмшигчээс илт бага хүүтэй зээл авсан; (хуулийн 7.2.6б) - Даатгалын тохиолдол бий болох үед Монголбанкны статистик мэдээллээр хадгаламж эзэмшигчдийн авч байгаа хадгаламжийн дундаж хүүгээс 50 хувиас илүү хүү авсан. (хуулийн 7.2.6в) 				
Г	АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛЫН ХУРААМЖ ТООЦОХ ХАДГАЛАМЖ	(А-Б-В13-В14)			
Д	Нийт даатгагдах харилцах, хадгаламж	(А-Б-В)			

Тайлан бэлтгэсэн огноо: (уууу.мм.дд)

Тайлан бэлтгэсэн: гарын үсэг / албан тушаал, нэр /

Тайлан хянасан: гарын үсэг / албан тушаал, нэр /

Хүлээн авсан: гарын үсэг / албан тушаал, нэр /

Хүлээн авсан огноо: (уууу.мм.дд)

БАНКНЫ НЭГДСЭН БАЛАНС

Банкны нэр:
(ууу.мм.дд)

Огноо:

Банкны код:

/Сая төгрөгөөр/

	ХӨРӨНГӨ	Томьёолол	Тайлант сарын үлдэгдэл		ӨР ТӨЛБӨР	Томьёолол	Тайлант сарын үлдэгдэл
A	МӨНГӨН ХӨРӨНГӨ	(1+2+15)		A	ХАРИЛЦАХ ДАНС	(1+...+5)	
1	Бэлэн мөнгө			1	Засгийн газар, төсөв, нийгмийн даатгал, халамж		
2	Банк, СБ-д байршуулсан хөрөнгө (цэврээр)	(3+8+13+14)		2	Улсын байгууллага		
3	Харилцах	(4+...+7)		3	Хувийн байгууллага		
4	Монголбанк			4	Иргэд		
5	Дотоодын банк			5	Бусад (Ха.бус, ор.суугч бус, сүм, үнэт мет)		
6	Дотоодын санхүүгийн байгууллага			B	ХАДГАЛАМЖ	(1+7+13)	
7	Гадаадын банк, санхүүгийн байгууллага			1	Хугацаагүй хадгаламж	(2+...+6)	
8	Хадгаламж	(9+...+12)		2	Засгийн газар, төсөв, нийгэм даатгал		
9	Монголбанк			3	Улсын байгууллага		
10	Дотоодын банк			4	Хувийн байгууллага		
11	Дотоодын санхүүгийн байгууллага			5	Иргэд		
12	Гадаадын банк, санхүүгийн байгууллага			6	Бусад		
13	Урвуу репо (мөнгөтэй адилтгах)			7	Хугацаатай хадгаламж	(8+...+12)	
14	/Эрсдэлийн сан/			8	Засгийн газар, төсөв, нийгэм даатгал		
15	Үнэт металл (цэвэр)			9	Улсын байгууллага		
B	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ (цэвэр)	(1+9+13)		10	Хувийн байгууллага		

1	Үнэт цаас (цэвэр)	(2+...+8)		11	Иргэд		
2	Засгийн газрын үнэт цаас			12	Бусад		
3	Төв банкны үнэт цаас			13	Бусад хадгаламж (сертификат, үнэт металл)		
4	Хувьцаа			В	БАНК, СБ-С ТАТСАН ЭХ ҮҮСВЭР	(1+6+11)	
5	Гадаадын үнэт цаас			1	Харилцах, хадгаламж	(2+...+5)	
6	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас			2	Монголбанк		
7	Вексель, Өрийн бичиг			3	Дотоодын банк		
8	Үнэт цаасны хорогдуулаагүй урамшуулал, хямдруулалт			4	Дотоодын санхүүгийн байгууллага		
9	Хараат болон охин компанид оруулсан хөөрөнгө оруулалт	(10+11+12)		5	Гадаадын банк, СБ, гадаадын салбар		
10	Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт			6	Зээл	(7+...+10)	
11	Хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт			7	Монголбанк		
12	Хяналттай аж ахуйн нэгжид оруулсан хөрөнгө оруулалт			8	Дотоодын банк		
13	/Эрсдэлийн сан/			9	Дотоодын санхүүгийн байгууллага		
В	ЗЭЭЛИЙН ӨРИЙН ҮЛДЭГДЭЛ (ЦЭВЭР)	(1+2+3+7)		10	Гадаадын банк, СБ, гадаадын салбар		
1	Хэвийн зээл			11	Бодит үнийн залруулга		
2	Анхаарал хандуулах			Г	БУСАД ЭХ ҮҮСВЭР	(1+...+5)	
3	Чанаргүй зээл	(4+5+6)		1	Дотоод гаргасан өрийн бичиг, үнэт цаас		
4	Хэвийн бус зээл			2	Гадаад гаргасан өрийн бичиг, үнэт цаас		
5	Эргэлзээтэй зээл			3	Үнэт цаасны урамшуулал, хямдруулалт		
6	Муу зээл			4	Төслийн зээлийн санхүүжилт		
7	/ЗТУБАХСАН/			5	Бусад (Репо, Хамтын Зэ.Эх.Үс, Бусад)		
8	Нийт зээл	(1+2+3)		Д	БУСАД ӨР ТӨЛБӨР	(1+...+5)	
Г	БУСАД ХӨРӨНГӨ	(1+...+10)		1	Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг		
1	Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага			2	Эх үүсвэрийн хойшлогдсон төлбөр		
2	Зээлийн хойшлогдсон төлбөр, бодит үнийн залруулга			3	Өглөг		

3	Авлага (цэвэр)			4	Банк, салбар хоорондын тооцоо		
4	Банк, салбар хоорондын тооцоо			5	Бусад		
5	Өмчлөх бусад хөрөнгө			Е	АРИЛЖАА (Дериватив санхүүгийн өглөг)		
6	Бусад тооцоо			Ё	ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН (А+Б+В+Г+Д+Е)		
7	Бараа материал, үнэ бүхий зүйл			Ж	ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	(1+...+8)	
8	Биет бус хөрөнгө			1	Хувь нийлүүлсэн хөрөнгө		
9	Татварын хөрөнгө			2	Халаасны хувьцаа		
10	Бусад			3	Нэмж төлөгдсөн капитал		
Д	АРИЛЖАА (Дериватив санхүүгийн хөрөнгө)			4	Тухайн жилийн ашиг /алдагдал/		
Е	ҮНДСЭН ХӨРӨНГӨ (цэвэр)	(1+2+3)		5	Өмнөх үеийн ашиг /алдагдал/		
1	Үндсэн хөрөнгө			6	Нөөцийн сан		
2	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө			7	Бусад		
3	Борлуулах зориулалттай хөрөнгө			8	Хоёрдогч өглөг (5-с дээш жилийн)		
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	(А+Б+В+Г+Д+Е)			ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	(Ё+Ж)	

Тайлан бэлтгэсэн огноо: (уууу.мм.дд)

Тайлан бэлтгэсэн: гарын үсэг / албан тушаал, нэр /

Тайлан хянасан: гарын үсэг / албан тушаал, нэр /

Хүлээн авсан: гарын үсэг / албан тушаал, нэр /

Хүлээн авсан огноо: (уууу.мм.дд)

ОРЛОГО ЗАРЛАГЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Банкны нэр:

Огноо: (yyyy.mm.dd)

Банкны код:

/Сая төгрөгөөр/

	Үзүүлэлт	Томьёолол	Тайлант сарын үлдэгдэл
А	Нийт орлого	(1+2+3+4+5)	
1	Үүнээс: Хүүгийн орлого		
2	Арилжааны орлого		
3	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого		
4	Шимтгэл, хураамжийн орлого		
5	Бусад орлого		
Б	Нийт зарлага	(1+2+3+4+5+6+7)	
1	Үүнээс: Хүүгийн зарлага		
2	Болзошгүй эрсдэлийн зарлага		
3	Арилжааны зарлага		
4	Ханш, үнэлгээний тэгшитгэлийн зарлага		
5	Боловсон хүчний зарлага		
6	Элэгдлийн зардал		
7	Бусад зардал		
В	Татварын өмнөх цэвэр ашиг	(А-Б)	
Г	Татварын зардал		
Д	Цэвэр ашиг	(В-Г)	

Тайлан бэлтгэсэн огноо: (yyyy.mm.dd)

Тайлан бэлтгэсэн: гарын үсэг / албан тушаал, нэр /

Тайлан хянасан: гарын үсэг / албан тушаал, нэр /

Хүлээн авсан: гарын үсэг / албан тушаал, нэр /

Хүлээн авсан огноо: (yyyy.mm.dd)

БАНКНЫ АКТИВ, ПАССИВЫН ЭРГЭН ТӨЛӨГДӨХ ХУГАЦААНЫ ТАЙЛАН

Банкны нэр:

Огноо: (yyyy.mm.dd)

Банкны код:

/Сая төгрөгөөр/

Хөрөнгө		Хугацаагүй	1-30 өдөр	1-3 сар	3-6 сар	6-12 сар	1-2 жил	2-5 жил	5 жилээс дээш	Нийт
1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө									
2	Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө									
3	Монголбанкны үнэт цаас									
	Засгийн газрын үнэт цаас									
	Бусад үнэт цаас									
4	Засгийн газар, улсын байгууллагад олгосон зээл									
	Банк, санхүүгийн байгууллагад олгосон зээл									
	Хувийн аж ажуй нэгжид олгосон зээл									
	Иргэдэд олгосон зээл									
	Бусад зээл									
5	Дериватив санхүүгийн хөрөнгө*									
6	Хугацаагаар ангилж болох бусад хөрөнгө									
A	НИЙТ САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ (1+...+6)									
Өр төлбөр		Хугацаагүй	1-30 өдөр	1-3 сар	3-6 сар	6-12 сар	1-2 жил	2-5 жил	5 жилээс дээш	Нийт
1	Харилцах									
2	Монголбанкны хадгаламж, зээл									
	Засгийн газар, улсын байгууллагын хадгаламж, зээл									
	Банк, санхүүгийн байгууллагын хадгаламж, зээл									

	Хувийн аж ажуй нэгжийн хадгаламж, зээл									
	Иргэдийн хадгаламж, зээл									
	Бусад хадгаламж, эх үүсвэр									
3	Банкнаас гаргасан үнэт цаас, өөрийн бичиг									
4	Дериватив санхүүгийн хөрөнгийн өглөг*									
5	Хугацаагаар ангилж болох бусад (2догч өглөгийг оруулна)									
Б	НИЙТ САНХҮҮГИЙН ӨР ТӨЛБӨР (1+...+5)									
Цэвэр зөрүү (А-Б)										
Цэвэр зөрүү (өссөн дүнгээр)										

Тайлбар:

Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага, өглөгийг оруулахгүй.

Дериватив санхүүгийн хөрөнгөд балансын гадуур бүртгэлтэй байгаа үндсэн хэлцлийн хугацаагаар тусгана.

Тайлан бэлтгэсэн огноо: (yyyy.mm.dd)

Тайлан бэлтгэсэн: гарын үсэг / албан тушаал, нэр /

Тайлан хянасан: гарын үсэг / албан тушаал, нэр /

Хүлээн авсан: гарын үсэг / албан тушаал, нэр /

Хүлээн авсан огноо: (yyyy.mm.dd)

БАНКНЫ ГАДААД ВАЛЮТЫН НЭЭЛТТЭЙ ПОЗИЦИЙН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Банкны нэр:

Огноо: (уууу.мм.дд)

Банкны код:

(Сая төгрөгөөр)

	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	Нэгж валют (Мянган нэгжээр)									Тэнцлийн дүн	
		Томьёолол	USD	EUR	JPY	GBP	CNY	KRW	CHF	Бусад USD	USD (Сая.\$)	MNT
A	ГАДААД ВАЛЮТЫН АКТИВ	(1+...+5)										
1	Мөнгөн хөрөнгө											
2	Хөрөнгө оруулалт (цэвэр)											
3	Зээлийн үлдэгдэл (цэвэр)											
4	Бусад хөрөнгө											
5	Арилжаа (Дериватив санхүүгийн хөрөнгө)											
B	ГАДААД ВАЛЮТЫН ПАССИВ	(1+...+6)										
1	Харилцах											
2	Хадгаламж											
3	Банк, СБ-с татсан эх үүсвэр											
4	Бусад эх үүсвэр											
5	Бусад өр төлбөр											
6	Арилжаа (дериватив санхүүгийн өглөг)											
B	ТЭНЦЛИЙН ГАДУУРХ ДАНС	(1+...+4)										
1	Баталгаа											
2	Батлан даалт											
3	Аккредитив											
4	Бусад хүлээж болзошгүй үүрэг											
Г	ГАДААД ВАЛЮТЫН НЭЭЛТТЭЙ ПОЗИЦ	(A-B-B)										
	ХАНШ*											

Тайлбар:

Тухайн сарын валютын эцсийн ханшийг оруулна.

Тайлан бэлтгэсэн огноо: (уууу.мм.дд)

Тайлан бэлтгэсэн: гарын үсэг / албан тушаал, нэр /

Тайлан хянасан: гарын үсэг / албан тушаал, нэр /

Хүлээн авсан: гарын үсэг / албан тушаал, нэр /

Хүлээн авсан огноо: (уууу.мм.дд)

ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Банкны нэр:

Огноо: (yyyy.mm.dd)

Банкны код:

№	Үзүүлэлт	Зохистой харьцаа	Тайлант сар
1	Өөрийн хөрөнгийн хүрэлцээ	=> 12%	
2	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн харьцаа	=> 9%	
3	Нэг зээлдэгч, түүнд холбогдох этгээдэд олгосон зээлийн нийт өөрийн хөрөнгөнд эзлэх хувь	<= 20%	
4	Үндсэн хөрөнгийн харьцаа	<= 8%	
5	Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нийт валют)	±30%	
6	Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нэгж валют)	±15%	
7	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	>= 25%	

Тайлан бэлтгэсэн огноо: (yyyy.mm.dd)

Тайлан бэлтгэсэн: гарын үсэг / албан тушаал, нэр /

Тайлан хянасан: гарын үсэг / албан тушаал, нэр /

Хүлээн авсан: гарын үсэг / албан тушаал, нэр /

Хүлээн авсан огноо: (yyyy.mm.dd)

ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Банкны нэр:

Огноо: (yyyy.mm.dd)

Банкны код:

/Сая төгрөгөөр/

	Үзүүлэлт	Тайлант сарын үлдэгдэл
1	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө	
2	Өөрийн хөрөнгө (Ө.Х)	
3	Эрсдэлээр жигнэсэн актив	
4	Нийт актив	
5	Цэвэр хүлээж болох үүрэг	

/Сая төгрөгөөр/

	Үзүүлэлт	Томьёолол	Тайлант сарын үлдэгдэл
	ӨӨРИЙН ХӨРӨНГӨ (I+II)		
I	1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө	(1+2+3+4-5-6+7+8-9)	
1	Хувьцаат капитал /ердийн хувьцаа/		
2	Халаасны хувьцаа		
3	Нөөцийн сан		
4	Тухайн жилийн ашиг, алдагдал		
5	Өмнөх үеийн хуримтлагдсан ашиг, алдагдал		
6	Нэмж төлөгдсөн хувьцаа (ердийн хувьцаа)		
7	Хандивын капитал		
8	Бусад		
9	Тохируулгын нэмэгдэх хасагдах гүйлгээ		
II	2-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө	(10+11+12+13+14+15-16)	
10	Хувьцаат капитал /давуу эрхтэй хувьцаа/		
11	Нэмж төлөгдсөн хувьцаа (давуу эрхтэй хувьцаа)		
12	Дахин үнэлгээний нэмэгдэл		
13	Хоёрдогч өглөг /5-аас дээш жилийн хугацаатай/		
14	Нийгмийн хөгжлийн сан		
15	Бусад		
16	Тохируулгын нэмэгдэх хасагдах гүйлгээ		

Тайлан бэлтгэсэн огноо: (yyyy.mm.dd)

Тайлан бэлтгэсэн: гарын үсэг / албан тушаал, нэр /

Тайлан хянасан: гарын үсэг / албан тушаал, нэр /

Хүлээн авсан: гарын үсэг / албан тушаал, нэр /

Хүлээн авсан огноо: (yyyy.mm.dd)

**ЗЭЭЛИЙН БАГЦЫН МЭДЭЭЛЭЛ (САЛБАРЫН АНГИЛЛААР)
БОЛОН ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН САНГИЙН МЭДЭЭЛЭЛ**

Банкны нэр
Огноо: (уууу.мм.дд)
Банкны код:

		/Сая төгрөгөөр/
№	Зээлийн эрсдэлийн сангийн мэдээлэл	Тайлант сарын үлдэгдэл
1	Зээлийн эрсдэлийн сан	
2	Зээлийн эрсдэлийн сангаас хаасан зээлийн дүн	
3	Зээлийн барьцаа /а+б+в/	
	а. Хэвийн бус	
	б. Эргэлзээтэй	
	в. Муу	

/Сая төгрөгөөр/					
Зээлийн багц (салбарын ангиллаар)					
№	Нийт зээлийн өрийн үлдэгдэл	Тайлант сарын үлдэгдэл	№	Чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл	Тайлант сарын үлдэгдэл
1	Уул уурхай, олборлолт		1	Уул уурхай, олборлолт	
2	Боловсруулах үйлдвэрлэл		2	Боловсруулах үйлдвэрлэл	
3	Бөөний болон жижиглэн худалдаа		3	Бөөний болон жижиглэн худалдаа	
4	Барилга		4	Барилга	
5	Үл хөдлөх хөрөнгө		5	Үл хөдлөх хөрөнгө	
6	Бусад		6	Бусад	
	Нийт (1+2+3+4+5+6)			Нийт (1+2+3+4+5+6)	

Тайлан бэлтгэсэн огноо: (уууу.мм.дд)

Тайлан бэлтгэсэн: гарын үсэг / албан тушаал, нэр /

Тайлан хянасан: гарын үсэг / албан тушаал, нэр /

Хүлээн авсан: гарын үсэг / албан тушаал, нэр /

Хүлээн авсан огноо: (уууу.мм.дд)

БҮТЭЦ ӨӨРЧЛӨГДСӨН АКТИВ

Банкны нэр:

Огноо: (yyyy.mm.dd)

Банкны код:

/Сая төгрөгөөр/

№	Активын төрөл	Өмнөх сарын үлдэгдэл	Эргэн төлөгдсөн	Шинээр БӨ* ангилалд шилжсэн	Хэвийн ангилалд хэвээр байгаа эсвэл шилжсэн	Бусад тохируулга	Тайлант сарын үлдэгдэл
1	Зээл (Нийт)						
	Хэвийн						
	Анхаарал хандуулах						
	Чанаргүй зээл (а+б+в)						
	а. Хэвийн бус						
	б. Эргэлзээтэй						
	в. Муу						
2	Үнэт цаас						
3	Авлага болон бусад актив						
4	Бусад						
	Нийт						

*БӨ-Бүтэц өөрчлөгдсөн

БАГЦАЛСАН АКТИВЫН ПАРАМЕТР ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАЙЛАН

№	Багцын төрөл	Параметрийн тооцоо*			Хамгийн их-Хамгийн бага**						Тооцсон аргачлал	Хамрах хугацаа		Нийт ажиглалтын тоо (observations)	Мэдээллийн давтамж*** (сар, улирал, хагас жил, жилээр гэх мэт)
		PD	LGD	LIP	PD		LGD		LIP			Эхлэх огноо	Дуусах огноо		
					max	min	max	min	max	min					
1	Орон сууцны...														
2	Жижиглэн...														
3	Төлбөрийн картын...														
4	Бичил санхүү...														
5	Хэрэглээний...														

....															
	Гэх мэт...														

*Тэгээс цааших гурван орны нарийвчлалтай

**Параметрийг тооцох хугацааны туршид тооцож байсан хамгийн их болон хамгийн бага утга

***Жилийн давтамжтай бол 1, хагас жилийн-2, улирлын-3, сарын-4-ийг тус тус бичнэ.

Тайлан бэлтгэсэн огноо: (yyyy.mm.dd)

Тайлан бэлтгэсэн: гарын үсэг / албан тушаал, нэр /

Тайлан хянасан: гарын үсэг / албан тушаал, нэр /

Хүлээн авсан: гарын үсэг / албан тушаал, нэр /

Хүлээн авсан огноо: (yyyy.mm.dd)

ХАДГАЛАМЖ ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХҮЛЭЭН АВАХ SCV ЗАГВАР

Хүснэгт 0100-Банкны мэдээлэл бүртгэх

Банкны мэдээлэл бүртгэх хүснэгт (SCV_Document)		
Талбарын нэр	Төрөл	Тайлбар
Bank_Id	Integer	Монгол банкин дээр бүртгэлтэй банкны код /эхний 2 орон/
Bank_Legal_Name	String	Тухайн банкны хуулийн этгээдийн нэр
Bank_BIC	Char(8)	Банкны BIC код
Bank_Register	Char(7)	Банкны регистр
Tn_Depositors	Integer	Нийт харилцах, хадгаламж эзэмшигчдийн тоо
Tn_Deposits	Integer	Нийт харилцах, хадгаламжийн дансны тоо
Ta_Deposits	Float	Нийт харилцах, хадгаламжийн дансны үлдэгдэл
Tn_Loans	Integer	Нийт зээлийн дансны тоо
Ta_Loans	Float	Нийт зээлийн дансны үлдэгдэл
Exported_Date	Timestamp	Өгөгдөл экспортолсон огноо
Event_Date	Date	Даатгалын тохиолдол бий болсон өдөр

Хүснэгт 0110-Валютын ханш

Валютын харилцах, хадгаламж болон зээлийн дансны үлдэгдлийг төгрөгөөр илэрхийлэх тооцоололдоо ашигласан валютын ханшны мэдээлэл. (Монгол банкны тухайн өдрийн ханшийг ашиглана).

Валютын ханшийн мэдээлэл (Currency_Rate) Валютын харилцах, хадгаламж болон зээлийн дүнг тооцоолох ханшийн мэдээллийг бүртгэх		
Талбарын нэр	Төрөл	Тайлбар
Bank_Id	Integer	Монгол банкин дээр бүртгэлтэй банкны код /эхний 2 орон/
Currency_Code	Char(3)	Валютын код. Төгрөгийн дансны хувьд 'MNT' гэсэн утга бичигдэнэ.
Currency_Rate	Float	Тухайн валютын нэгжтэй тэнцэх төгрөгийн ханшийг оруулна. Энэхүү ханш нь харилцах, хадгаламж болон зээлийн

		валютын дүнг төгрөгөөр шилжүүлэхэд ашиглагдсан байна.
Currency_Name	String	Тухайн валютын нэр

Хүснэгт 0200-Хадгаламж эзэмшигч

Харилцах, хадгаламж эзэмшигчид болон хамтран эзэмшигчдийн мэдээлэл.

Хадгаламж эзэмшигчийн мэдээлэл (Depositor) Харилцагчийн мэдээллийг бүртгэх		
Талбарын нэр	Төрөл	Тайлбар
Bank_Id	Integer	Монгол банкин дээр бүртгэлтэй банкны код /эхний 2 орон/
CIF	String	Бүх хэрэглэгч банкны систем дээр дахин давтагдашгүй дугаартай байдаг.
Type	Integer	Хавсралт 1-ийн Depositor_type хүснэгтийн Id талбараас харгалзах утга авна.
Name *	String	Type = Person тохиолдолд Surname талбар, “Хоосон зай” болон Given_Name талбарыг залгасан байдлаар утга оруулах ба бусад тохиолдолд Харилцагчийн хуулийн этгээдийн нэрийг оруулна.
Sex	Char(1)	Эрэгтэй бол 'M', эмэгтэй бол 'F'
Given_Name*	String	Харилцагчийн өөрийн нэр. (Хадгаламж эзэмшигч нь хувь хүн тохиолдолд утга оруулна)
Surname*	String	Эцэг эхийн нэр. (Хадгаламж эзэмшигч нь хувь хүн тохиолдолд утга оруулна)
Family_Name*	String	Ургийн овог. (Хадгаламж эзэмшигч нь хувь хүн тохиолдолд утга оруулна)
Register*	String	Регистр. (Хадгаламж эзэмшигч нь хувь хүн тохиолдолд утга оруулна)
Birth_Date	Date	Төрсөн он, сар, өдөр
Email*	String	Имэйл хаяг
Citizenship	String	Иргэншил(Тухайн улсын 2 үсэгт товч код зураас аваад монгол нэршил. Жишээ нь: MN-МОНГОЛ RU-ОХУ KR-ӨМНӨД СОЛОНГОС)
Trading_Name*	String	Хэрэв хуулийн этгээдийн нэрээс өөр нэрийг бизнесийн зорилгоор ашигладаг бол тухайн бизнесийн нэр. (Хадгаламж эзэмшигч нь байгууллага тохиолдолд утга оруулна)
Registration_No*	Char(10)	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 10 оронтой дугаар. (Хадгаламж эзэмшигч нь байгууллага тохиолдолд утга оруулна)
Entity_Register	Char(7)	Байгууллагын 7 оронтой регистр дугаар. (Хадгаламж эзэмшигч нь байгууллага тохиолдолд утга оруулна)
Director_Name*	String	Гүйцэтгэх захирлын нэр (овог “хоосон зай” болон нэрийг залгана). (Хадгаламж

		эзэмшигч нь байгууллага тохиолдолд утга оруулна)
--	--	--

Хүснэгт 0210-Хаяг

Харилцах, хадгаламж эзэмшигчдийн хаягийн мэдээлэл. Нэг харилцагч нэг л хаягтай байна.

Харилцагч болон хамтрагчийн хаягийн бүртгэл (Address) Харилцагч болон хамтрагчийн хаягийн мэдээллийг бүртгэх		
Талбарын нэр	Төрөл	Тайлбар
Bank_Id	Integer	Монгол банкин дээр бүртгэлтэй банкны код /эхний 2 орон/
CIF	String	Бүх хэрэглэгч банкны систем дээр дахин давтагдашгүй дугаартай байдаг.
Type	Integer	Хавсралт 1-ийн Address_Type хүснэгтийн Id талбараас харгалзах утга авна.
Address*	String	Хаяг (Хороолол, хороо, гудамж, байр, орц, хаалга).
M_District	String	Хороо.
District_Name	String	Дүүргийн нэр.
Province_Name City_Name	String	Аймаг, мужийн нэр. Хотын нэр
Country_Name	String	Улсын нэр.

Хүснэгт 0220-Утас

Харилцагчийн холбоо барих утасны мэдээлэл. Нэг харилцагч нэг л утасны дугаартай байна.

Харилцагчийн холбоо барих утасны бүртгэл (Phone) Харилцагч болон хамтрагчийн холбоо барих утасны мэдээллийг бүртгэх		
Талбарын нэр	Төрөл	Тайлбар
Bank_Id	Integer	Монгол банкин дээр бүртгэлтэй банкны код /эхний 2 орон/
CIF	String	Бүх хэрэглэгч банкны систем дээр дахин давтагдашгүй дугаартай байдаг.
Type	Integer	Хавсралт 1-ийн Phone_Type хүснэгтийн Id талбараас харгалзах утга авна.
International_Code	String	Олон улсын код
Regional_Code	String	Бүсийн код
Phone_No*	String	Дугаар

Extension_Code	String	Дотоод дугаар.
Contact_Name*	String	Холбоо барих хүний нэр (овог “хоосон зай” болон нэрийг залгана). Тухайн хадгаламж, эзэмшигчээс өөр нэр байж болно.

Хүснэгт 0300-Хадгаламжийн данс

Харилцах, хадгаламжийн дансны мэдээллүүд.

Харилцах, хадгаламжийн мэдээлэл (Deposit_Account) Харилцах, болон хадгаламжийн дансны мэдээллийг бүртгэх		
Талбарын нэр	Төрөл	Тайлбар
Bank_Id	Integer	Монгол банкин дээр бүртгэлтэй банкны код /эхний 2 орон/
CIF	String	Бүх хэрэглэгч банкны систем дээр дахин давтагдашгүй дугаартай байдаг.
Deposit_Account_Type	Integer	Хавсралт 1-ийн Deposit_Account_Type хүснэгтийн Id талбараас харгалзах утга авна.
Type	Integer	Хавсралт 1-ийн Deposit_Type хүснэгтийн Id талбараас харгалзах утга авна.
Account_Status	String	Идэвхтэй, идэвхгүй данс, хөдөлгөөнгүй
Product_Name	String	Хадгаламжийн бүтээгдэхүүний дэлгэрэнгүй нэр. {Хүүхдийн хадгаламж, Орон сууцны хадгаламж 36 сар, гэх мэт }
Product_Term	Integer	Хугацаа (сар)
Opening_Date	Date	Данс нээсэн огноо
Start_Date	Date	Хүү бодож эхэлсэн хугацаа
End_Date	Date	Хүү бодож дуусах хугацаа
Branch_Code	String	Банкны салбарын BIC дугаар. (Банк хоорондын их дүнтэй төлбөр тооцооны системд ашиглагддаг)
Account_Number	String	Дансны дугаар
Currency_Code	Char(3)	Валютын код (MNT, USD, EUR г.м.)
Account_Balance	Float	Дансны үлдэгдэл (Валютаар)
Account_Balance_MNT	Float	Дансны үлдэгдэл (Төгрөгөөр). Гадаад валютын данс тохиолдолд тухайн

		өдрийн Монголбанкны албан ханшаар төгрөгт шилжүүлсэн дүн бичигдэнэ.
Interest_Type	String	Хүүний төрөл: Энгийн болон Нийлмэл
Accrued_Interest	Float	Хуримтлагдсан хүүгийн үлдэгдэл (Валютаар)
Accrued_Interest_MNT	Float	Хуримтлагдсан хүүгийн үлдэгдэл (Төгрөгөөр). Гадаад валютын данс тохиолдолд тухайн өдрийн Монголбанкны албан ханшаар төгрөгт шилжүүлсэн дүн бичигдэнэ.
Effective_Annual_Interest_Rate	Float	Хамгийн сүүлд мөрдөгдөж байгаа хүү (%)
Cap_Date	Date	Кап хүү олгосон сүүлийн өдөр

Хүснэгт 0305-Хадгаламжийн дансны хуулга

Харилцах, хадгаламжийн дансны Кап хүү олгосон сүүлийн өдрөөс тохиолдлын өдөр хүртэлх хадгаламжийн дансны өдөр бүрийн хуулга

Харилцах, хадгаламжийн дансны өдөр бүрийн хуулга (Deposit_Account_Statement)		
Талбарын нэр	Төрөл	Тайлбар
TxnDate	Date	Тухайн өдрийн огноо
CIF	String	Бүх хэрэглэгч банкны систем дээр дахин давтагдашгүй дугаартай байдаг.
Branch_Code	String	Банкны салбарын BIC дугаар. (Банк хоорондын их дүнтэй төлбөр тооцооны системд ашиглагддаг)
Account_Number	String	Дансны дугаар
Current_Bal	Float	Тухайн өдрийн дансны үлдэгдэл
Interest_Rate	Float	Хүүний хувь
Currency_Code	Char(3)	Валютын код (MNT, USD, EUR г.м.)
Txn_Amount	Float	Хуримтлагдсан хүүний дүн

Хүснэгт 0310-Харилцах, хадгаламжийн дансны хамтран эзэмшигч

Харилцах, хадгаламжийн дансны хамтран эзэмшлийн талаарх мэдээлэл. Тухайн дансны үндсэн эзэмшигчээс бусад хамтран эзэмшигчдийн холбоост түлхүүрүүдийг агуулна. Харилцах, хадгаламжийн гэрээн дээр эзэмшлийн талаар ямар нэгэн хувь заагдаагүй тохиолдолд нийт үндсэн эзэмшигч болон хамтран эзэмшигчид нар ижил тэнцүү хувь эзэмшиж буй гэж үзнэ.

Харилцах, хадгаламжийн хамтран эзэмшлийн мэдээлэл (Deposit_Joint_Owner) Харилцах, болон хадгаламжийн дансны хамтран эзэмшлийн мэдээллийг бүртгэх		
Талбарын нэр	Төрөл	Тайлбар
Bank_Id	Integer	Монгол банкин дээр бүртгэлтэй банкны код /эхний 2 орон/
CIF	String	Бүх хэрэглэгч банкны систем дээр дахин давтагдашгүй дугаартай байдаг.
CIF_Joint	String	Харилцах, хадгаламжийн хамтран эзэмшигчийн CIF дугаар
Account_Number	String	Хамтарсан дансны дугаар
Percentage_Of_Claim	Float	Харилцах, хадгаламж эзэмшигчид оногдох хувь

Хүснэгт 0400-Зээлийн данс

Харилцах, хадгаламж эзэмшигчдийн зээлийн дансны мэдээлэл. Нэг харилцагч олон зээлтэй байж болох бөгөөд зээлийн данс тус бүрээр бичилт хийгдэнэ.

Зээлийн мэдээлэл (Loan_Account) Зээлийн мэдээллийг бүртгэх		
Талбарын нэр	Төрөл	Тайлбар
Bank_Id	Integer	Монгол банкин дээр бүртгэлтэй банкны код /эхний 2 орон/
CIF	String	Бүх хэрэглэгч банкны систем дээр дахин давтагдашгүй дугаартай байдаг.
Product_Name	String	Зээлийн бүтээгдэхүүний дэлгэрэнгүй нэр. {Цалингийн зээл, Тэтгэврийн зээл, Мортгэйж, зээлийн карт, гэх мэт}
Product_Term	Float	Хугацаа (сар)
Borrowed_Date	Date	Данс нээсэн огноо

Branch_Code	Char(11)	Банкны салбарын BIC дугаар. (Банк хоорондын их дүнтэй төлбөр тооцооны системд ашиглагддаг)
Account_Number	String	Дансны дугаар
Currency_Code	Char(3)	Валютын код (MNT, USD, EUR г.м)
Principal_Balance	Float	Үндсэн зээлийн хэмжээ
Payments	Float	Эргэн төлсөн хэмжээ
Account_Balance	Float	Дансны үлдэгдэл (Валютаар)
Account_Balance_MNT	Float	Дансны үлдэгдэл (Төгрөгөөр). Гадаад валютын данс тохиолдолд тухайн өдрийн Монголбанкны албан ханшаар төгрөгт шилжүүлсэн дүн бичигдэнэ.
Effective_Annual_Int	Float	Хамгийн сүүлд мөрдөгдөж байгаа хүү (%)
Cap_Fine_Int	Float	Торгуулийн хүү (%)
Cap_Principal_Int	Float	Кап үндсэн хүү
Cap_Commitment_Int	Float	Кап коммитмент хүү
Cap_Penalty_Rate	Float	Кап нэмэгдүүлсэн хүү
Principal_Day_Int	Float	Үндсэн өдрийн хүү
Commitment_Day_Int	Float	Коммитмент өдрийн хүү
Penalty_Day_Rate	Float	Нэмэгдүүлсэн өдрийн хүү
Principal_Outstanding_Int	Float	Үндсэн хур хүү
Commitment_Outstanding_Int	Float	Коммитмент хуримтлагдсан хүү
Penalty_Outstanding_Rate	Float	Нэмэгдүүлсэн хуримтлагдсан хүү
Principal_Loan_Debt	Float	Үндсэн зээлийн өр
Principal_Int_Debt	Float	Үндсэн хүүний өр
Off_Bal_Cap_Principal_Int	Float	Балансын гадуурх Кап үндсэн хүү
Off_Bal_Cap_Commitment_Int	Float	Балансын гадуурх Кап коммитмент хүү
Off_Bal_Cap_Penalty_Rate	Float	Балансын гадуурх Кап нэмэгдүүлсэн хүү
Off_Bal_Date	Float	Балансын гадуурх гарсан огноо
Credit_Class	Integer	Ангилал
Credit_Rating	Boolean	Хэрвээ зээлийн үнэлгээ 1,2 бол True; зээлийн үнэлгээ 3,4,5 бол False
Account_Status	String	Идэвхтэй, идэвхгүй данс

Хүснэгт 0405 - Зээлийн дансны хуулга

Зээлийн дансны Кап хүү олгосон сүүлийн өдрөөс тохиолдлын өдөр хүртэлх зээлийн дансны өдөр бүрийн хуулга

Зээлийн дансны өдөр бүрийн хуулга (Loan_Account_Statement)		
Талбарын нэр	Төрөл	Тайлбар
TxnDate	Date	Тухайн өдрийн огноо
CIF	String	Бүх хэрэглэгч банкны систем дээр дахин давтагдашгүй дугаартай байдаг.
Branch_Code	String	Банкны салбарын BIC дугаар. (Банк хоорондын их дүнтэй төлбөр тооцооны системд ашиглагддаг)
Account_Number	String	Дансны дугаар
Current_Bal	Float	Тухайн өдрийн дансны үлдэгдэл
Interest_Rate	Float	Хүүний хувь
Currency_Code	Char(3)	Валютын код (MNT, USD, EUR г.м.)
Txn_Type	String	Хуримтлагдсан хүүний төрөл
Txn_Amount	Float	Хуримлагдсан хүүний дүн

Хүснэгт 0410-Хамтран зээлдэгч

Зээлийн хамтран хариуцагчийг бүртгэнэ.

Хамтран зээлийн мэдээлэл (Co_Borrower) Харилцах, болон хадгаламжийн дансны хамтран эзэмшлийн мэдээллийг бүртгэх		
Талбарын нэр	Төрөл	Тайлбар
Bank_Id	Integer	Монгол банкин дээр бүртгэлтэй банкны код /эхний 2 орон/
CIF	String	Бүх хэрэглэгч банкны систем дээр дахин давтагдашгүй дугаартай байдаг.
CIF_Joint	String	Хамтран зээлдэгчийн CIF дугаар

Account_Number	String	Хамтарсан дансны дугаар
Percentage_Of_Claim	Float	Хамтрагчид оногдох хувь

Хүснэгт 0500-Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, хувьцаа эзэмшигч болон тэдгээртэй хамааралтай этгээдүүдийн мэдээлэл

Банкны үндсэн системээс гарах боломжгүй мэдээллүүд болох банкны төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүд болон тэдгээртэй хамааралтай этгээдүүдийн мэдээллийг өөр эх үүсвэрээс (хүний нөөцийн програм хангамж, Монгол банк г.м) доорх загварын дагуу авч НТС-д ачаалан НТ-ийн хэмжээг тооцохдоо ашиглана.

Банкны ажилчид, удирдлага, хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл (Relationship)		
Талбарын нэр	Төрөл	Тайлбар
Bank_Id	Integer	Монгол банкин дээр бүртгэлтэй банкны код /эхний 2 орон/
CIF	String	Бүх хэрэглэгч банкны систем дээр дахин давтагдашгүй дугаартай байдаг.
Given_Name	String	Өөрийн нэр
Surname	String	Овог нэр
Register_ID	String	Регистрийн дугаар
Address_1	String	Гэрийн хаяг
Address_2	String	Гэрийн хаяг, түр оршин суугаа хаяг г.м
Relationship_Info	String	Банкны саналын эрхтэй хувьцааны 50 болон түүнээс дээш хувийг эзэмшиж буй хуулийн этгээд болон тэдгээрийн хувьцаа эзэмшигч, банкны саналын эрхтэй хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг шууд ба шууд бусаар эзэмшдэг иргэн, тухайн банкны төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүд г.м

Хүснэгт 0600-Нөхөн төлбөр олгохгүй хадгаламж

Даатгалд хамаарахгүй болон нөхөн төлбөр тооцох шаардлагагүй хадгаламжийн дансны мэдээлэл бүртгэх хүснэгт.

Нөхөн төлбөр олгохгүй хадгаламж бүртгэх (Uninsured)		
Талбарын нэр	Төрөл	Тайлбар
Bank_Id	Integer	Монгол банкин дээр бүртгэлтэй банкны код /эхний 2 орон/

CIF	String	Бүх хэрэглэгч банкны систем дээр дахин давтагдашгүй дугаартай байдаг.
Account_Number	String	Дансны дугаар
Uninsured_reason	String	Банкны санхүүгийн байдал муудахад нөлөөлсөн, банкны үйлчилгээ авахдаа санхүүгийн давуу эрх эдэлсэн нь тогтоогдсон хадгаламж, даатгагдаагүй хадгаламжийн жагсаалт

Хүснэгт 0700-Нөхөн төлбөр олгохоос түр түдгэлзүүлсэн харилцах, хадгаламж

Түр хугацаанд түдгэлзүүлэх хадгаламж болон харилцахын мэдээллийг бүртгэх хүснэгт.

Түр түдгэлзүүлэх харилцах, хадгаламж бүртгэх (Suspended)		
Талбарын нэр	Төрөл	Тайлбар
Bank_Id	Integer	Монгол банкин дээр бүртгэлтэй банкны код /эхний 2 орон/
CIF	String	Бүх хэрэглэгч банкны систем дээр дахин давтагдашгүй дугаартай байдаг.
Account_Number	String	Дансны дугаар
Suspension_reason	String	Шалтгаан: <ul style="list-style-type: none"> • Царцаасан • Түр зогсоосон • Гуравдагч тал болон бусад санхүүгийн байгууллагад барьцаалагдсан хадгаламж • Хадгаламж барьцаалсан зээл • Кредит карт
Suspended_Date	Date	Огноо
Suspended_Amount	Float	Үлдэгдэл дүн

Dictionary Table

Depositor_Type

Id	Description
100	Иргэн
101	7.1.1 Иргэн - Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1-д заасан этгээдийн нэргүй, дугаарласан, эсхүл хуурамч нэрээр нээсэн данс;
102	7.1.2 Иргэн - нэргүй хадгаламжийн сертификат болон бусад төрлийн нэргүй санхүүгийн хэрэгсэл;
103	7.1.3 Иргэн - нэрлэсэн үнээр эргэж төлөгдөхгүй хадгаламж.
104	7.2.4 Иргэн - Банкны тухай хуулийн 3.1.2-т заасан банкны холбогдох этгээд;
105	7.2.6.а Иргэн - гүйлгээний төрөл, эрсдэлийн түвшин, зээлдэгчийн төлбөрийн чадвар болон барьцааны төрөл зэргийг харгалзан үзэхэд бусад хадгаламж эзэмшигчээс онцгой нөхцөлтэй зээл авсан;
106	7.2.6.б Иргэн - банкны бусад хадгаламж эзэмшигчээс илт бага хүүтэй зээл авсан;
107	7.2.6.в Иргэн - даатгалын тохиолдол бий болох үед Монголбанкны статистик мэдээллээр хадгаламж эзэмшигчдийн авч байгаа хадгаламжийн дундаж хүүгээс 50 хувиас илүү хүү авсан.
200	Хуулийн этгээд
201	7.1.1 Хуулийн этгээд - Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4.1-д заасан этгээдийн нэргүй, дугаарласан, эсхүл хуурамч нэрээр нээсэн данс;
202	7.1.2 Хуулийн этгээд - нэргүй хадгаламжийн сертификат болон бусад төрлийн нэргүй санхүүгийн хэрэгсэл;
203	7.1.3 Хуулийн этгээд - нэрлэсэн үнээр эргэж төлөгдөхгүй хадгаламж.
204	7.2 Хуулийн этгээд - Дараах этгээдийн хадгаламж хадгаламжийн даатгалд хамаарахгүй:
205	7.2.1 Хуулийн этгээд - банк;
206	7.2.2 Хуулийн этгээд - төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага;
207	7.2.3 Хуулийн этгээд - эрүүл мэндийн, тэтгэврийн болон нийгмийн албан журмын даатгалын сан;
208	7.2.4 Хуулийн этгээд - Банкны тухай хуулийн 3.1.2-т заасан банкны холбогдох этгээд;
209	7.2.5 Хуулийн этгээд - даатгалын тохиолдол бий болохоос өмнөх гурван жилийн хугацаанд банкны санхүүгийн тайланд аудит хийсэн аудитор болон аудитын байгууллага;
210	7.2.6 Хуулийн этгээд - Монголбанкны хяналт шалгалтын тайлангаар банкны санхүүгийн байдал муудахад нөлөөлсөн, банкны үйлчилгээ авахдаа санхүүгийн давуу эрх эдэлсэн нь тогтоогдсон дор дурдсан хадгаламж эзэмшигч:

211	7.2.6.а Хуулийн этгээд - гүйлгээний төрөл, эрсдэлийн түвшин, зээлдэгчийн төлбөрийн чадвар болон барьцааны төрөл зэргийг харгалзан үзэхэд бусад хадгаламж эзэмшигчээс онцгой нөхцөлтэй зээл авсан;
212	7.2.6.б Хуулийн этгээд - банкны бусад хадгаламж эзэмшигчээс илт бага хүүтэй зээл авсан;
213	7.2.6.в Хуулийн этгээд - даатгалын тохиолдол бий болох үед Монголбанкны статистик мэдээллээр хадгаламж эзэмшигчдийн авч байгаа хадгаламжийн дундаж хүүгээс 50 хувиас илүү хүү авсан.
214	7.3 Хуулийн этгээд - Даатгалын тохиолдол бий болоход энэ хуулийн 7.2-т заасан этгээдэд даатгалын нөхөн төлбөр төлөхгүй.
215	7.4 Хуулийн этгээд - Даатгалын тохиолдол бий болоход Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу битүүмжилсэн болон Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 11.1-д заасны дагуу гүйлгээг нь түдгэлзүүлсэн дансны хадгаламж эзэмшигчид зөвхөн битүүмжлэх болон гүйлгээг түдгэлзүүлэх шийдвэр хүчингүй болсон тохиолдолд даатгалын нөхөн төлбөрийг олгоно.

Address_Type

Id	Description
1	Байнгын
2	Түр
3	Бизнесийн

Phone_Type

Id	Description
1	Гар утас
2	Ажлын утас
3	Гэрийн утас
4	Факс

Deposit_Account_Type

Id	Description
1	Харилцах данс
2	Хугацаатай данс
3	Хугацаагүй данс
4	Гэх мэт - уг жагсаалтад ороогүй төрлийг банк нэмж болно.

Deposit_Type

Id	Description
1	Насанд хүрээгүй хадгаламж эзэмшигчийн данс
2	Аккредитив данс
3	Өв залгамжлагч
4	Итгэлцлийн данс
5	Гэх мэт - уг жагсаалтад ороогүй төрлийг банк нэмж болно.

**Банк хадгаламжийн даатгалын тогтолцоо, даатгалын нөхөн төлбөрийн хэмжээний
талаар хадгаламж эзэмшигчдэд мэдээлэл хүргэсэн тухай тайлан**

Банкны нэр:

Огноо: (yyyy.mm.dd)

№	Мэдээллийн зорилго	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн үзүүлэлт	Тайлагнах
1	Хадгаламжийн даатгалын тогтолцооны тухай харилцагч, хадгаламж эзэмшигчдэд мэдээлэл хүргэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	1.1. Корпорациас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ- (фэйсбүүк, твитер, youtube суваг)-гээр дамжуулан мэдээлэл хүргэсэн байх	1.1-д заасны дагуу мэдээлэл хүргэсэн байх	Баримтжуулсан зураг, холбогдох линкийн хамт тайлагнах
		1.2. Корпорациас санаачилсан аян, арга хэмжээг дэмжиж ажиллах, байгууллага болон нутаг дэвсгэрийн онцлогт тохируулан зохион байгуулах	Дэмжиж хамтран ажилласан байх	Үр дүнг тайлагнах
		1.3. Хадгаламжийн даатгалын үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах, мэдээллийн самбар ажиллуулах	Корпорациас хүргүүлсэн мэдээллийг байршуулж, тогтмол шинэчлэх	Мэдээлэл байршуулсан тухай холбогдох зургийн хамт тайлагнах
2	Хадгаламжийн даатгалын тогтолцооны талаар сургалт зохион байгуулах	2.1. Корпорациас зохион байгуулдаг Хадгаламжийн даатгалын тогтолцооны тухай сургалтад ажилтнуудыг хамруулах	Сургалтад хамруулах санал, захиалга өгсөн байх,	Сургалтын зураг, хамарсан ажилтнуудын тоог тайлагнах
		2.2. Дотоод сургалтын хөтөлбөртөө хадгаламжийн даатгалын тухай мэдээлэл оруулсан байх	Сургалт зохион байгуулсан байх	Сургалт зохион байгуулсан огноо, хамрагдсан ажилтнуудын тоо,
		2.3. Корпорациас бэлтгэж өгсөн тестийн дагуу ажилтнуудын хадгаламжийн даатгалын тухай мэдлэгийн түвшинг тогтоох ажлыг зохион байгуулах	Мэдлэгийн түвшин тогтоох тест авсан байх	Тестийн үр дүнг тайлагнасан байх / хамарсан тоо, мэдлэгийн түвшин/
3	Байгууллагын цахим хуудас, аппикэйшн болон хэвлэмэл материалд мэдээлэл байршуулах	3.1. Харилцах болон хадгаламжийн дансны бүтээгдэхүүн сурталчилгаанд "Таны 20 сая хүртэлх төгрөг Хадгаламжийн даатгалын корпорациар даатгагдсан" мэдээллийг оруулах	3.1-д заасан мэдээллийг байршуулсан байх	Мэдээлэл байршуулсан линк, зургийн хамт хүртээмжийн талаар тайлагнах